



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/202

Мөрөн сум


Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 31.5 дахь хэсэг, 2021 оны Сангийн сайдын 61 дүгээр тушаалын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн А/363 дугаар захирамжид Орон нутгийн өмчийн газрын дарга гэснийг Худалдан авах ажиллагааны газрын дарга болгож, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга, Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Хөвсгөл аймаг дахь салбарын дарга гэснийг тус тус хасаж өөрчлөлт оруулсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ